



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/125

Хэрлэн сум

Захирамжид өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 08 дугаар хуралдааны 04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 08 дугаар хуралдааны 04 дүгээр тогтоолын 2, 4, 5 дугаар хавсралтаар батлагдсан хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтаас аймгийн Засаг даргын “Эрх шилжүүлэх тухай” 2022 оны А/02 дугаар захирамжаар батлагдсан сумдад эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтаас “Зах зээл ба бэлчээрийн удирдлага хөгжил төслийн хөрөнгөөр байгуулсан ногооны борлуулах цэгийн гадна тохижилтын орон нутгаас шийдвэрлэх санхүүжилт (Хэрлэн сум)” төсөл, арга хэмжээг хассугай.

2. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны
 03 дугаар сарын 03 өдрийн
 захирамжийн хавсралт

№	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний нэр	Хугацаа		Төсөвт өртөг	2021 онд санхүүжих	Эрх шилжүүлсэн ТЭЗ
		Эхлэх	Дуусах			
Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх барилга, байгууламж төсөл, арга хэмжээний жагсаалт						
1	Аялал жуулчлалын музейд тоноглол, эд хогшил (Дадал)	2022	2022	25,000.0	25,000.0	Дадал сумын Засаг дарга
	Нийт дүн			25,000.0	25,000.0	
Аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт						
1	Хүнсний ногооны зорийн цахилгаан хангамж (Мөрөн сум)	2022	2022	20,000.0	20,000.0	Мөрөн сумын Засаг дарга
2	Соёлын төвийн тоног төхөөрөмж (Баян-Овоо сум)	2022	2022	5,000.0	5,000.0	Баян-Овоо сумын Засаг дарга
3	Соёлын төвийн тоног төхөөрөмж (Батноров сум)	2022	2022	15,000.0	15,000.0	Батноров сумын Засаг дарга
4	Соёлын төвийн тоног төхөөрөмж (Биндэр сум)	2022	2022	15,000.0	15,000.0	Биндэр сумын Засаг дарга
5	Соёлын төвийн тоног төхөөрөмж (Гурванбаян тосгон)	2022	2022	15,000.0	15,000.0	Гурванбаян тосгоны Захирагч
6	Хогны менежментийг хэрэгжүүлэх (Баянмөнх сум)	2022	2022	80,000.0	80,000.0	Баянмөнх сумын Засаг дарга
7	Шүдний тоног төхөөрөмж (Дархан сум)	2022	2022	19,000.0	19,000.0	Дархан сумын Засаг дарга
8	Эмнэлгийн тоног төхөөрөмж (Батширээт сум)	2022	2022	20,000.0	20,000.0	Батширээт сумын Засаг дарга
9	Эрүүл мэндийн төвийн моргийн хөргүүр (Норовлин сум)	2022	2022	8,000.0	8,000.0	Норовлин сумын Засаг дарга
10	Тосгоны тохижилт, гэрэлтүүлгийн зураг төсөл (Бэрх тосгон)	2022	2022	20,000.0	20,000.0	Бэрх тосгоны Захирагч
	Нийт дүн			217,000.0	217,000.0	
Аймгийн хөрөнгө оруулалтаар 2022 оны төсвийн жилд хэрэгжүүлэх их засварын төсөл, арга хэмжээний жагсаалт						
1	Усан оргилууруудын засвар (Хэрлэн сум)	2022	2022	55,300.0	55,300.0	Хэрлэн сумын Засаг дарга
2	Сургуулийн барилгын их засвар (Дархан сум)w	2022	2023	280,000.0	230,000.0	Дархан сумын Засаг дарга
				335,300.0	285,300.0	
	Нийт дүн			577,300.0	527,300.0	